



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 08 өдөр

Дугаар A1507

Алтай хот

┌ **Аймгийн Улаан загалмайн хороонд** ┐
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.1, 1.1.2, 2.6.2, 2.7.1, 4.4.1 дэх заалтууд, Засаг даргын зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 37 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Аймгийн Улаан загалмайн хорооны гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон сайн дурын гишүүдийг чадавхжуулах, шинээр бэлтгэх, зорилтот бүлгийн иргэдэд халамж, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх зардлыг хавсралтаар баталсугай.

2.Шаардагдах 9,191,000 (есөн сая нэг зуун ерэн нэгэн мянга) төгрөгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2021 оны
11 дугаар сарын 08 ны өдрийн 1507 дугаар
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Үйл ажиллагаа	Дүн
Халамж		
1	30-50 сайн дурын идэвхитнийг олон нийтэд тулгуурласан халамж үйлчилгээг үзүүлэхэд элсүүлж, сургаж, идэвхжүүлж ажиллах;	625000
2	Нэг сайн дурын идэвхтэн 3 халамжлуулагчид гэрийн үйлчилгээ, асаргаа үзүүлэх;	720000
3	Зорилтот бүлгийн сургалт зохион байгуулж, мэдлэг, мэдээлэл олгох;	450000
Эрүүл мэнд		
4	Олон нийтэд чиглэсэн эрүүл мэнд анхны тусламжийн сургалтыг сайн дурын идэвхтнүүдийн дунд зохион байгуулах;	319500
5	Аж, ахуйн нэгж байгууллага, иргэд, олон нийтэд чиглэсэн коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах	750000
6	Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр сурталчилгааны ажлыг олон нийт, байгууллага хамт олон, зорилтот бүлгийн /хүүхэд залуучууд, өндөр настан, эмзэг бүлгийнхэн/ дунд зохион байгуулах	670000
Гамшгийн менежмент		
7	Анхан шатны хороод болон томоохон аж ахуйн нэгж, байгууллагуудад анхны тусламжийн нөхөрлөлийг байгуулж, давтан сургалт зохион байгуулах;	1020000
Сайн дурынхан гишүүдийн хөгжил		
8	Хүнлэг энэрэнгүй үйлсийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг хүүхэд залуучууд, олон нийтийн дунд зохион байгуулах;	470000
9	Анхан шатны хороонд өсвөрийн/залуучуудын улаан загалмайн клуб байгуулж ажиллах;	300000
10	"Клуб 25"-ын үйл ажиллагааг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулах;	100000
11	Гамшигт нэрвэгдсэн улс орон, ард иргэдэд хөрөнгө босгох үйл ажиллагааг зохион байгуулах;	3366500
12	Дунд шатны улаан загалмайн хороо бүрт Хүүхэд Залуучуудын Хөдөлгөөний клуб ажилладаг байх;	400000
ДҮН		9191000